

## ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА POLICE ORGANIZATION MANAGEMENT FOR ENSURING ROAD TRAFFIC SAFETY

**Э.Энхболд**

ДХИС-ийн Удирдлагын академийн 8021 дүгээр дамжааны суралцагч, цагдаагийн хошууч.

**Enkhbold. E**

Master student in the 8021st course of Leadership Academy of the University of Internal Affairs, Mongolia, police major

**Товч агуулга:** Энэхүү илтгэлийн зорилго нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг системийн онолын хандлагаар тайлбарлах, нөлөөлөгч хүчин зүйлүүдийн харилцан хамаарал, зүй тогтлыг тодорхойлох, цагдаагийн байгууллагаас цаашид хэрхэн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах мэргэжлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгох боломжтой талаар санал, зөвлөмж боловсруулахад оршино.

**Abstract:** This article's purpose is to explain the theory of road traffic safety from a systems perspective, identify the interrelationships and regularities of influencing factors, and develop suggestions and recommendations on how the police can create an effective professional management system to ensure traffic safety in the future.

**Түлхүүр үгс:** Замын хөдөлгөөний аюулгүй байдал, замын хөдөлгөөний удирдлага, мэргэжлийн удирдлага, зам тээврийн осол.

**Keywords:** Road safety, traffic management, professional management, road accidents.

### Оршил

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан статистик мэдээлэлд зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүний тоо 2010 онд 1.25 сая байсан бол 2021 онд амь насаа алдсан хүний тоо 5.9 хувиар буурч 1.18 сая орчим болсон байна. Хэдийгээр дэлхийн хэмжээнд хүн ам, автомашины тоо өсөн нэмэгдэж байгаа боловч

сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд улс орнууд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зөв бодлого, стратегийг авч хэрэгжүүлсний үр дүнд 7 сая гаруй хүнийг зам тээврийн ослын улмаас амь насаа алдах эрсдэлээс авран хамгаалж чаджээ <sup>147</sup>. Зам тээврийн ослын хор уршгийг эдийн засгийн тоон утгаар нь авч үзвэл улс орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүний 3

<sup>147</sup> World health statistics 2024: Monitoring health for the SDGs, sustainable development goals. -Geneva., 2024. 17 дахь тал.

хувьтай тэмцэх хэмжээний бодит хохирлыг учруулж байгаа судалгааг мөн дээрх байгууллагын тайлан мэдээнд дурдсан байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2020 оны 74 дүгээр хуралдаанаас улс орнуудад “Дэлхийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах бодлого, стратеги /2021-2030 он/-ийг хэрэгжүүлэх замаар зам тээврийн ослоор амь насаа алдах, гэмтэж бэртэх хүмүүсийн тоог хоёр дахин бууруулах зорилт тавьсан.

Мөн Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас “2030 он хүртэл хэрэгжүүлэх Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бүс нутгийн стратеги”-ийг 2016 онд баталсан бөгөөд эдгээр тогтоол, стратегийг Монгол Улс дэмжиж гарын үсэг зурсан.

Манай улсад 2023 оны статистик дүн мэдээгээр 1,192,520 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна <sup>148</sup>. Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд “11.1.3.замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах”, мөн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цагдаагийн байгууллагад үүрэг болгосон “8.1.1.замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавих”, “8.1.2.замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг хангах зорилгоор замын хөдөлгөөнийг зохицуулах” гэсэн үүргүүдийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд

цагдаагийн байгууллагаас 2023 онд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн нийт 2,945,490 зөрчлийг илрүүлж 83.8 тэрбум төгрөгийн торгууль оногдуулсан байна.

Хэдийгээр зөрчил илрүүлэлтийн хувь хэмжээ нь бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнд оролцож буй жолооч нарын тоотой харьцуулахад өндөр байгаа боловч зам тээврийн ослын улмаас тухайн онд 3059 хүн гэмтэж, 551 хүн амь насаа алдаж, 50.7 тэрбум төгрөгийн эд материалын хохирол учирсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоолоор батлагдсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги /2012-2020 он/-ийн хэрэгжилтийг 2018 онд хүрсэн түвшнээр нь авч үзэхэд 54 хувьтай, мөн 2019 оны Засгийн газрын 163 дугаар тогтоолоор баталсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2019-2023 он/-ийн хэрэгжиж дууссан боловч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлогын зорилтот түвшинд хүрэхгүй байна.

Үүнээс дүгнэхэд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг оновчтой тодорхойлж, төлөвлөх хэрэгцээ шаардлага байна гэдэгтэй салбарын судлаач, мэргэжилтнүүд санал нэгддэг.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсан. Энэхүү баримт бичгийн 7 дугаар бүлэгт хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, амар тайван

<sup>148</sup> Зам, тээврийн хөгжлийн яам. Зам, тээврийн салбарын статистикийн эмхэтгэл 2023 он. - Уб., 2024. тал 4.

аюулгүй нийгмийг бүрдүүлэх, хууль сахиулах салбарын хөгжлийн чиг хандлагын талаар тодорхой тусгаж өгчээ. Тухайлбал, “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилт 7.4.2 дахь хэсэгт “Салбарын инновацын үйл ажиллагааг дэмжих хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна<sup>149</sup>” гэж заасан.

Цагдаагийн байгууллагаас шинэчлэн боловсруулж буй “Цагдаа, дотоодын цэргийн бодлогын баримт бичиг /2024-2029/” хөгжлийн хөтөлбөрийн төслийн 3.2.2. Онол суурьтай цагдаагийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилтын 3.2.2.1.-т Цагдаа, хууль сахиулах байгууллагын удирдлагын шинжлэх ухаан, мөрдөн шалгах, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны олон улсын суурь онолуудыг удирдамж болгох талаар тус тус дурдсан байна.

Иймд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны онолын үндэс, нөлөөлөгч хүчин зүйлүүдийн харилцан хамаарал, зүй тогтлыг тодорхойлж, цаашид цагдаагийн байгууллагын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах үйл ажиллагааны удирдлага стратегийг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах замаар Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэдийн амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, мөн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан замын хөдөлгөөнд оролцогчдын замын хөдөлгөөний дүрмийг баримтлан

саадгүй зорчих, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох нөхцөлөө хангуулахаар төрийн холбогдох байгууллага, албан тушаалтанд шаардлага тавих зэрэг эрхүүдийг хангуулах нь хууль сахиулах байгууллагуудын хүлээх чухал үүрэг юм.

### **Нэг. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны онолын үндэс**

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг эрх зүйн талаас зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнээс учирч болох хохирлыг багасгахад чиглэгдсэн үйл ажиллагаа юм гэж тодорхойлохын зэрэгцээ авто зам, гүүр, түүний хиймэл байгууламжийг төлөвлөх, шинээр барих, өргөтгөх, засварлах, ашиглах, тээврийн хэрэгсэл, түүний эд анги, сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэх, ашиглахад хяналт тавих ажиллагааг мөн хамааруулсан байдаг.

Дэлхийн улс орнууд аюулгүй байдлыг хангах хариу арга хэмжээний цар хүрээг нарийн тэлж, дараах гурван асуудлыг анхаарч үзэх болсон. Үүнд, нийгмийн хөгжил, эдийн засгийн хөгжил, экосистемийг хэвээр нь хадгалах гэсэн “Тогтвортой хөгжлийн гурвалжин” загвар -ыг боловсруулж, аюулгүй байдлын аливаа асуудалд хандахдаа зөвхөн нэг өнцгөөс хандах биш, харин түүний бүх элементийн хоорондын харилцан хамаарлыг тооцож системийн хандлагаар хандах шаардлагатай гэж үзэх болсон.

Учир нь аюулгүй байдлын тухай ойлголт нь хувь хүн, нийгэм, улс орны амин чухал эрх ашгийг дотоод,

<sup>149</sup> Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол. “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичиг.

гадаадын аюулаас хамгаалах үүрэгтэй салшгүй холбоотой байдаг. Тиймээс ч “Аюулгүй байдлыг хангах” гэдэг нь хүний амь бие, эрүүл мэнд, эрх, эрх чөлөө, нийгэм, төрийн үйл ажиллагаанд учрах аливаа жижиг эрсдэлээс эхлэн тэдгээрийн амин чухал эрх ашгийг хамгаалах хүртэл яригдах онол практикийн өргөн цар хүрээтэй ойлголт юм.

Аюулгүй байдлын зарим судлаачид аливаа үйлдвэрлэл, үйл ажиллагааны зохих стандартыг баримтлаагүй, эсвэл холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг мөрдөөгүйн улмаас үүсэх үзэгдэл, үр дагавар бүрийг амин чухал эрх ашигт тулсан заналхийллээр төсөөлөн анхаарал хандуулах ёстой талаар зөвлөсөн байдаг. Иймд аюулгүй байдлын чиглэлээр судалгаа хийж буй судлаачид аюулгүй байдлын тухай ухагдахуун бүрд анхаарал хандуулж, өргөн цар хүрээнд судалж, олон дахин хэлэлцэн байж тулгамдсан асуудалд шинжлэх ухаанчаар хандах нь аливаа жижиг гэлтгүй эрсдэлийг бууруулан нийгмийн амьдралын чанарыг дээшлүүлэхээс эхлээд улс орны тусгаар тогтнол, улс нийгмийн язгуур эрх ашгийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг системийн онолын үүднээс авч үзвэл хоорондоо зүй тогтлын дагуу харилцан холбоотой элементүүдээс бүрдсэн харьцангуй тогтвортой шинж чанар бүхий нэг бүхэл цогц тогтолцоо байдаг. Өөрөөр хэлбэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлын систем нь олон тооны элементүүдээс бүрдэх бөгөөд эдгээр элементүүдийн хоорондох харилцан хамаарал тодорхой зүй тогтол, нийцэлтэй байх нь аюулгүй байдал хангагдах суурь нөхцөлийг бүрдүүлдэг төдийгүй

аюулгүй байдлын ерөнхий онолын үндсийг танин мэдэхгүйгээр салбар тус бүрийн аюулгүй байдлуудыг хангах боломжгүй юм. Тиймээс тухайн системд хамаарах элементүүдийн зүй тогтол, хамаарлыг нарийн тооцож үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлснээр цагдаагийн байгууллага нь иргэдийнхээ өмнө хуулиар хүлээсэн үүрэгт хамаарах эрүүл аюулгүй орчинд тэдний амьдрах, чөлөөтэй зорчих эрхийг эдлүүлэхэд ахиц гарах боломжтой.

Аюулгүй байдлын системийн элемент тус бүр дангаараа ялгаатай шинж чанарыг агуулж байх боловч систем нь тэдгээрээсээ ялгаатай шинж чанарыг агуулдаг тул элемент хоорондын харилцан хамаарал нь субординацийн хуульд захирагдах зүй тогтолтой байдаг. Субординацийн хуулийн дагуу замын хөдөлгөөний аюулгүй байдлын онолын ерөнхий зүй тогтол нь систем дэх нэг элемент өөрчлөгдөхөд бусад нь мөн адил өөрчлөгдөж харьцангуй тогтвортой шинж чанар алдагдсанаар зам тээврийн осол, зөрчил үйлдэгдэж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулдаг байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын онолыг системийн хандлагын өнцгөөс тайлбарлах, нөлөөлөгч хүчин зүйлүүдийн харилцан хамаарлыг тодорхойлохын тулд “Аюулгүй байдлын тогтолцоо”, “Аюулгүй байдлыг хангах тогтолцоо”-ны талаарх онолын ойлголтуудыг авч үзэх шаардлагатай.

Судлаач Ч.Улаанхүү “Аюулгүй байдал” бүтээлдээ аюулгүй байдлын шинжлэл, судлалын хувьд “Бүхэл” гэдэг ойлголтод аль ч объект, түвшин, масштабын хувьд ялгаагүй “Субъект-объект-аюулгүй байдлын тогтолцоо” гэсэн загвартай гэж тодорхойлсон.

Тухайлбал, “Аюулгүй байдлын субъект” – гэдэг нь нөхцөл байдалд идэвхтэй нөлөө үзүүлж, аюулгүй байдлын аль нэгэн төрлийн төлөө хариуцлага хүлээж, түүний талаар шийдвэр гаргаж, амьдралд хэрэгжүүлж байх үүрэгтэй хувь хүн, хамт олон байгууллага юм. “Аюулгүй байдлын объект” – гэдгийг сөрөг өөрчлөлтийн нөлөөнд орсноор үндэсний ашиг сонирхолд ноцтой нөлөөлж болох элементийг аюулгүй байдлын объект гэдэг. Аливаа аюулгүй байдлын объект бие хүн (иргэн), түүний эрх, эрх чөлөө, үүрэг, нийгэм, түүний материаллаг ба оюуны үнэт зүйлс, төр, түүний үндсэн хуульт төрийн байгуулалт, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлаар илэрнэ<sup>150</sup> гэжээ.

Харин “Аюулгүй байдлын тогтолцоо” /систем/ - нь тодорхой зорилготой эрх зүйн хэм хэмжээ, хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын байгууллагууд тэрчлэн, аюулгүй байдлын найдвартай хамгаалалтыг хангах зориулалт бүхий дээрх байгууллагуудын техник хэрэгсэл, арга, чиглэлийн нэгдэл юм<sup>151</sup> гэж тайлбарлажээ.

Хэрэглээний хувьд аюулгүй байдлын тогтолцоо, аюулгүй байдлыг хангах тогтолцоо гэсэн нэр томъёо нь хоорондоо ойролцоо мэт боловч агуулгын хувьд ялгаж үзэх зайлшгүй шаардлагатай юм<sup>152</sup>. Аюулгүй байдлын тогтолцоо нь аюулгүй байдлын объектод аюул занал хэрхэн нөлөөлж байгаагаас нь хамаараад аюулгүй байдлыг төрөлжүүлэн ангилж, хамрах хүрээг тодорхойлсноор аюулгүй

байдлын тогтолцоог бий болгож, бүрдүүлдэг байна.

Харин аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь аюулгүй байдлыг хангах эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаа, чиглэлээс нь хамаарч төрөлжүүлсэн зохион байгуулалт, бүтэц, тэдгээрээс хэрэгжүүлэх арга хэмжээний тогтолцоог бий болгож байгаагаараа ялгаатай байдаг.

Тиймээс замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаа, чиглэлээс нь хамаарч аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг буюу элементүүдийн хэвийн найдварт ажиллагааг хангуулах зорилготой явуулж буй үйл ажиллагааны нэгдэл юм.

Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндсийг тодорхойлж, холбогдох харилцааг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль (2015)-аар зохицуулсан байдаг. Тус хуулийн 7.1.-т “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах үүргийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөл хэрэгжүүлнэ.” гэж заасан байдаг. Учир нь замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөгч хүчин зүйлд “Хүн, автомашин, зам, орчин” гэсэн үндсэн 4 элементийн сөрөг нөлөөллийг тооцож үздэг. Хүн гэдэгт замын хөдөлгөөнд оролцогчид, тэдгээрийн тусгай мэдлэг боловсрол эзэмшсэн байдал, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах

<sup>150</sup> Карпов, Н.И., Павлов, Д.Б. “Основы теории обеспечения безопасности личности, общества и государства” учебное пособие. - Москва, 2000. 30 дахь тал.

<sup>151</sup> Улаанхүү, Ч. Аюулгүй байдал. - Уб., 2009. 107 дахь тал.

<sup>152</sup> Булган, Д. Олон нийтийн аюулгүй байдлын нэр томъёоны зарим асуудал. Эрдэм шинжилгээний илтгэл. “Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. - Уб., 2016. 142 дахь тал.

чиглэлээр үүрэг хүлээсэн албан тушаалтан, иргэдийн асуудал хамаардаг.

Автомашин гэдэгт зөвхөн тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлаас гадна түүнийг эвдрэл гэмтэлгүй байлгахад шаардлагатай засварын төв, хяналт тавих оношилгооны тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн худалдаа, нийлүүлэлт зэргийг хүртэл нарийн тооцож хамааруулах ёстой. Харин замын тухайд техникийн зураг зурахаас авхуулаад ашиглалтад хүлээж авах, арчлалт хийх зэрэг олон үйл ажиллагааны харилцан үйлчлэлд замын аюулгүй байдал хангагдана. Мөн орчны нөлөөллийг тооцохдоо нийгэм эдийн засгийн байдал, хууль эрх зүйн орчин, газар зүйн байршил, цаг агаарын хэлбэлзэл, уламжлалт зан үйл, соёлын гэсэн өргөн хүний асуудлыг багтаан авч үзэх шаардлагатай байдаг.

Нөлөөлөгч хүчин зүйлсээс харахад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах үйл ажиллагаа нь дан ганц цагдаагийн байгууллагын хариуцах ажил бус хууль зүйн, техникийн, барилга, хот төлөвлөлт, эрүүл мэнд, боловсрол гэх зэрэг олон салбар шинжлэх ухааны огтлолцол дээр буюу засгийн газрын олон чиг үүргийн яамдын харилцан ойлголцол, үйл ажиллагааны нэгдэл дээр оршиж байдаг нарийн төвөгтэй харилцаа юм.

Тиймээс замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны онолын үндэс нь олон салбартай холбогдсон байдаг бөгөөд энэ нь замын хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хамгаалах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, замын

хөдөлгөөнийг зохицуулахтай холбоотой олон цогц арга хэмжээг аюулгүй байдлын онол, зарчимд суурилсан шийдлээр төлөвлөн хэрэгжүүлэх ёстой. Түүний зэрэгцээ нийгмийн салбар бүлгүүдийн хамтын ажиллагаа, төрийн нэгдсэн бодлого, аюулгүй байдлын зэрэглэлийг дээшлүүлэх технологийн дэвшил зэргийг хамтад нь авч үзэх шаардлагатай.

### **Хоёр. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны удирдлагыг оновчтой хэрэгжүүлж буй олон улсын туршлага**

Анх Америкийн Нэгдсэн Улс 1968 оноос, Япон Улсад 1970 оноос эхлэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиудаа батлан ослыг бууруулах үндэсний хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлснээр жил бүр нэмэгдэх автомашины тоо, хүн амын өсөлттэй хамааралтай гарч болзошгүй зам тээрийн ослын тохиолдол, хор уршгийг бууруулж чадсан юм<sup>153</sup>.

Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор 1975-2007 оны хооронд 12 өөр улсад зохион байгуулсан замын хөдөлгөөний аюулгүй байдлын 119 төрлийн кампанит ажлын үр дүнд Филиппин Улсын судлаачид шинжилгээ хийж үзэхэд зам тээврийн ослын тоо дунджаар 9 хувиар буурсан үзүүлэлт гарсан байна<sup>154</sup>. Эдгээр кампанит ажил буюу арга хэмжээнүүд нь зам тээврийн осол гаргахад хамгийн их сөрөг нөлөө үзүүлэгч элемент болох жолоочийн эрсдэлт зан үйлийг арилгах, буруу дадлыг багасгахад чиглэгдсэн зар

<sup>153</sup> Пугачев, И.Н. “Организация и безопасность движения”. -Хабаровск., 2004. 7 дахь тал.

<sup>154</sup> Ulleberg, P. Vaa, T. “Meta-analysis of the effect of road safety campaigns on accidents.”-Phillips RO.,2011.

сурталчилгааны хэв загварт суурилсан байжээ.

Испани Улсын Валенсиягийн болон Яумейн их сургуулиудын DATS - (Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хөгжил, зөвлөгөө) судалгааны групп, INTRAS - (Замын хөдөлгөөний аюулгүй байдлын судалгааны хүрээлэн"-ийн судлаачдын 2021 онд зам тээврийн ослыг бууруулах чиглэлээр зохион байгуулсан кампанит ажлын үр дүнгийн тухай нийтэлсэн нийт 27 төрлийн судалгааны илтгэлтэй танилцаж тухайн арга хэмжээний үр нөлөө ямар байсан талаар судлан үзжээ <sup>155</sup>. Гэтэл тэдгээр илтгэлд дурдагдсан кампанит ажлын үндсэн хэлбэр, агуулга нь замын хөдөлгөөнд оролцогчдын эрсдэлтэй хандлага, зан үйл нь тэднийг осолд өртөхөд нөлөөлдөг тул буруу зан үйлээ засах, анхаарах талаар сурталчлан ойлгуулах зорилготой зар сурталчилгааны хэв загварт суурилсан кампанит ажлыг улс орнууд зохион байгуулсан талаар байжээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар иргэдэд мэдээлэл хүргэх арга замаар тэднийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх кампанит ажлыг анх эрүүл мэндийн салбарт түлхүү ашиглаж, иргэдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор явуулж ирсэн байдаг. Мэдээж тэр ч утгаараа зам тээврийн ослын улмаас иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад зар сурталчилгаанд суурилсан хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан олон аян, акц, арга хэмжээг гадаадын зарим улсын хууль сахиулах байгууллагаас зохион байгуулж байна. 20-р зууны эхэн үед

хэвлэл мэдээллийн хэрэгслээр явагдах сурталчилгаа нь график, ярианы хэллэг түлхүү ашиглаж байсан бол 1990 оноос хойш замын хөдөлгөөнд оролцогчдын сэтгэл зүйд нөлөөлөх зам тээврийн ослын хор уршгийг харуулсан бодит зураг, бичлэг ашигласан хэлбэрт шилжсэн байна. Мөн иргэдэд илүү итгэл үнэмшил төрүүлэх зорилгоор олны танил урлаг соёлын алдартнуудыг оролцуулах байдлаар сэрэмжлүүлэг сурталчилгаа, зөвлөмж, анхааруулга бүхий агуулгатай контент, зурагт хуудас зэргийг ашиглах болсон байна.

Эдгээр 27 судалгааны илтгэлд тусгагдсан аян арга хэмжээнд жолоочийн эрсдэлт зан үйл болох согтуугаар автомашин жолоодох, хурд хэтрүүлэх, хамгаалах малгай хэрэглэх, шинэ туршлага багатай жолооч нарт чиглэсэн, хамгаалах бүс хэрэглэх, ядарсан үедээ жолоо барихгүй байх, хүүхдийн хамгаалалтын суудал хэрэглэх зэрэг эрсдэлт зан үйлийг бууруулах зорилгоор АНУ, Тайланд, Пакистан, Индонез, Австрали, Шинэ Зелланд, Грек, Испани, Канад зэрэг улс орнуудад явуулсан зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх аян арга хэмжээний үр дүнг дүгнэж үзэхэд дан ганц хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан явуулсан сурталчилгааны аян арга хэмжээ нь түр зуурын буюу богино хугацааны туршид үр нөлөөтэй боловч урт хугацаандаа үр нөлөөтэй байлгахын тулд сургалтын үйл ажиллагаа, хууль тогтоомжийн сайжруулалт, хяналт шалгалтын ажилтай хамтад нь зохион байгуулах нь урт хугацааны туршид эрсдэлээс замын хөдөлгөөнд оролцогч нарыг хамгаалах

<sup>155</sup> Mireia Faus. Francisco Alonso. Article "Are Traffic Announcements Really Effective? A Systematic Review of

Evaluations of Crash-Prevention Communication Campaigns"-Italia.,2021.

нөхцөл бий болох талаар дурдсан байна<sup>156</sup>.

Сүүлийн үед замын хөдөлгөөний аюулгүй байдлын салбарт тэргүүлэгч орнууд (жишээ нь Скандинавын орнууд, Герман) энгийн бөгөөд эдийн засгийн өртөг зардал бага шаардагдах шийдэл боломжуудыг амжилттай хэрэгжүүлж байна. Тухайлбал, замын хөдөлгөөний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, хүн амын янз бүрийн бүлэгт чиглэсэн сурталчилгаа хийх, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хүүхэд багачуудад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах, тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах, жолооч бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээг авч байна<sup>157</sup>.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг нь олон хүчин зүйлээс бүрддэг талаар өмнө дурдсан. Тухайн элементүүд нь аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдээр илэрч гарсан байдаг. Тухайлбал, гадаадын зарим улс орнууд болох Дани, Япон, Герман зэрэг аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа бусад дэлхийн улс орнуудаас сайн байгаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт дараах элементүүдийг авч үздэг.

## **1. Авто зам, замын байгууламж:**

*Замын чанар:* Авто замын их, ээлжит болон урсгал засвар, арчлалт нь аюулгүй байдлыг хангахад чухал үүрэгтэй байдаг. Авто замын зорчих хэсэгт үүссэн нүх, суурь бүтцийн суулт,

бохирдол зэрэг эвдрэл, гэмтэл нь аюулгүй байдалд эрсдэл учруулдаг.

*Замын хөдөлгөөн зохицуулах тэмдэг, тэмдэглэгээ:* Замын хөдөлгөөнд оролцогч нарын аюулгүй байдлыг хангах, тэдэнд зорчиж яваа авто замынх нь гормыг урьдчилан анхааруулах, мэдээлэх, заах, хориглох үйлдлийг ойлгуулахын тулд замын тэмдэг, тэмдэглэлийг холбогдох стандарт, дүрэм, журамд заасны дагуу зөв байршуулах шаардлагатай байдаг. Шаардлагатай тэмдэг нь байхгүй болсон, хэвтээ тэмдэглэл нь арилсан зэргээс аюултай нөхцөл байдал бий болдог.

*Замын байгууламж:* Гүүр, гүүрэн гарц, унадаг дугуй болон явган зорчигч, хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход зориулсан зам, ус зайлуулах хоолой, шуудуу, хонгил, замын хөдөлгөөнийг зохицуулах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай төхөөрөмж, авто замын зурвас газарт байгаа төлбөр авах цэг, авто зогсоол болон бусад байгууламжийг холбогдох стандарт, дүрэм, журамд заасны дагуу аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн барьж байгуулах, бүрэн бүтэн байлгах нь чухал юм.

## **2. Тээврийн хэрэгсэл:**

*Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал:* Замын хөдөлгөөнд оролцох үеийн техникийн аюулгүй байдал алдагдахад тухайн автомашины идэвхтэй, идэвхгүй аюулгүй байдлын эд анги, агрегат, зангилаа чухал байдаг.

*Тээврийн хэрэгслийн оношилгоо хяналт:* Замын хөдөлгөөнд оролцоход техникийн болон аюулгүй байдал,

<sup>156</sup> Mireia Faus. Francisco Alonso. Article “Are Traffic Announcements Really Effective? A Systematic Review of

Evaluations of Crash-Prevention Communication Campaigns”-Italia.,2021.

<sup>157</sup> Пугачев, И.Н. “Организация и безопасность движения”. -Хабаровск., 2004.

ашиглалтын норм, дүрэм, стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг оношилгоонд оруулах аргаар шалгадаг. Хэрэв оношилгооны үйл ажиллагааны процесст доголдол гарвал тээврийн хэрэгслийн аюулгүй байдалд эрсдэл учирдаг.

*Тээврийн хэрэгслийн техникийн засвар, үйлчилгээний баталгаатай байдал:* Баталгаагүй сэлбэг хэрэгсэл суурилуулсан тээврийн хэрэгсэл нь хөдөлгөөний явцад саатал, гэмтэл үүсэх, бусад хөдөлгөөнд оролцогч нарт аюул учруулах явдал маш их байдаг. Стандартаар зөвшөөрөхгүй хурц гэрэл, дугуй зэргийг тавьж суурилуулах нь шууд зам тээврийн осол, зөрчилд өртөх явдлыг нэмэгдүүлдэг.

### **3. Жолоочийн найдварт ажиллагаа:**

*Жолоочийн бэлтгэгдсэн байдал:* Жолоочийн мэргэжлийн сургалтын болон тээврийн хэрэгсэл жолоодох үйл ажиллагааны явцад бие даан суралцсан мэдлэг, ур чадварын түвшингээр тодорхойлогдоно. Жолооч бэлтгэх сургалтын үйл ажиллагааны чанар үр ашигтай байдлаас гадна суралцагчийн хувийн зан чанар, сэтгэлзүйн төлөв зэрэг хувийн онцлогоос хамаараалтай.

*Жолоочийн мэргэжилдээ тэнцэх байдал:* Энэ нь дан ганц биеийн эрүүл мэндээр тогтохгүй жолоочийн хувийн араншин, психофизиологийн /сэтгэл судлал/ шинж чанарыг агуулсан үнэлэмж бөгөөд өмнө тогтоосон шалгуурын дагуу эмчийн үзлэг, сэтгэл зүйчийн ярилцлага зэргээр тодорхойлогдоно.

*Жолоочийн ажиллах чадвар:* Жолоочийн ажиллаж амрах цагийн хуваарь, ажлын нөхцөл, тухайн үеийн биеийн эрүүл мэндийн байдал, хоолны дэглэм, янз бүрийн эм бэлдмэл, бусад холбогдох зүйлийг хэрэглэж байгаа

байдал, амьдралын хэв маяг зэрэг олон зүйлээс хамааралтай байдаг.

### **4. Явган зорчигчид болон бусад оролцогчид:**

*Явган зорчигчдын мэдлэг:* Замын хөдөлгөөнд оролцох туршлага, хандлага, зан байдал, насны онцлог, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олж авсан байдал, зам тээврийн ослын эрсдэлийг ойлгож мэдсэн байдал нь тэднийг ослоос урьдчилан сэргийлдэг.

*Бусад оролцогчдын үүргээ ухамсарласан байдал:* Бид бүгдийн гаргасан хайхрамжгүй үйлдэл, хуульд заасан үүргээ биелүүлээгүй байдал нь ямар нэгэн зам тээврийн осол, зөрчил гарахад нөлөөлдөг гэдэгтэй санал нийлэх байдал.

### **5. Хяналт, зохицуулалт:**

*Хууль сахиулах байгууллагын хяналт:* Дан ганц жолоочийн үйлдэлд хяналт тавихаар үйл ажиллагаагаа хязгаарлахгүй, замын хөдөлгөөнд нөлөөлөгч хүчин зүйлсийн хэвийн найдварт байдалд анхаарч бүх чиглэлд хүрч ажиллах. Яаралтай ослын дуудлагад шуурхай очих, зөрчилд тавих хяналтыг далд хэлбэрээр буюу хяналтын камерын тусламжтайгаар хянах ёстой. Мөн хууль эрх зүйн орчныг цаг үеийн тулгарсан бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхийн тулд тухайн бүр судалгаа шинжилгээнд үндэслэн шинэчлэх.

*Иргэдийн хяналт:* Зөвхөн хууль хяналтын байгууллага буруутай замын хөдөлгөөнд оролцогч нарт хяналт тавих ёстой гэсэн хандлагаас татгалзаж, нийгэм болон оршин суугаа газартаа дэг журмыг тогтооход дэмжлэг үзүүлж хамтран оролцох. Хууль хяналтын байгууллага иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд түлхүү анхаарал хандуулж ажиллах.

*Замын хөдөлгөөн зохицуулалт:* Тухайн нутаг дэвсгэрийн нутгийн

захиргааны байгууллага нь хууль сахиулах байгууллагын зөвлөмж, саналыг авч хариуцсан нутаг дэвсгэртээ замын хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл, шаардлагатай үед түгжрэл саатлыг бууруулах ажилтан томилон ажиллуулах ёстой. Хяналтын үйл ажиллагааг хууль сахиулах байгууллагаас авч хэрэгжүүлэхэд саад бэрхшээл болдог нэг үйл ажиллагаа нь зөрчилтэй тэмцэх бус хөдөлгөөнийг биетээр зохицуулах явдал байдгийг болиулах замаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хууль хяналтын байгууллагын удирдлагын үйл ажиллагааг авч хэрэгжүүлдэг байна.

**Гурав. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын өнөөгийн байдалд хийсэн судалгаа**

Аливаа төр улсын хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль хэрэгжих баталгааны гол нэг үндэс нь хууль сахиулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд баталгаажуулсан иргэдийн эрх, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-т “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн.” гэсэн хүний аюулгүй байдлыг хамгаалахад чиглэгдсэн үүргийг хариуцсан байгууллага, албан тушаалтан зайлшгүй анхаарч ажиллах ёстой.

Цагдаагийн байгууллагаас 2023 онд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн

нийт 2,945,490 зөрчлийг илрүүлж 83.8 тэрбум төгрөгийн торгууль оногдуулсан байна. Гэвч зөрчил илрүүлэлтийн хувь хэмжээ нь бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнд оролцож буй жолооч нарын тоотой харьцуулахад өндөр байгаа боловч зам тээврийн ослын улмаас тухайн онд 3059 хүн гэмтэж, 551 хүн амь насаа алдаж, 50.7 тэрбум төгрөгийн эд материалын хохирол учирсан байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт нь хэд хэдэн чухал асуудлыг хөнддөг. Эдгээр асуудлууд нь цагдаагийн байгууллагын ажлын үр дүн, аюулгүй байдлыг хангах, нийгэмд эрсдэлтэй нөхцөлүүдийг бууруулахад чухал үүрэгтэй. Тухайлбал, “Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох” ЦБҮАЖ Код 100-д заасны дагуу Тээврийн цагдаагийн алба хариуцдаг.

Тээврийн цагдаагийн албаны бүтэц зохион байгуулалтаас харахад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавих, мөн замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг хангах зорилгоор замын хөдөлгөөнийг зохицуулах гэсэн хоёр чиг үүргийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хүлээдэг. Тус албаны Замын цагдаагийн газар нь нутаг дэвсгэр хариуцсан нэгжүүд, замын тээврийн бодлого төлөвлөлтийн нэгж, тусгай хамгаалалтын нэгж, зам, тээврийн хяналтын нэгж, орон нутгийн замын хяналтын нэгж, нийслэлийн хөдөлгөөн зохицуулах гэрээт нэгж гэсэн үндсэн чиг үүргийн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Эдгээр нэгжүүдийн гүйцэтгэдэг гол үүрэг нь замын хөдөлгөөнд

оролцож яваа жолооч нарын үйлдэлд хяналт тавих, нэгжүүдийн алба хаагчдад заавар зөвлөмж өгөх, хамгаалалт зохицуулалт хийх, түгжрэл саатлыг бууруулах биет зохицуулалт хийх, нутаг дэвсгэр хариуцсан нэгжүүдийн мэдээ тайланг авч нэгтгэх гэсэн үйл ажиллагааг явуулж байна. Үүнээс үзэхэд замын хөдөлгөөнд нөлөөлөгч элементүүдэд бүрэн хяналт тавих удирдлагын бүтэц хараахан бий болоогүйг илтгэн харуулж байна. Цаашид системийн онолын хандлагаар хяналт тавих удирдлагын тогтолцоо, нэгжийн бүтцийг бий болгох шаардлагатай байна.

Дараагийн нэг анхаарах асуудал нь хүний нөөц, албан хаагчдын мэргэшсэн байдал, ажлын байрны чадавхжуулах сургалтын орчин нөхцөл бүрдсэн эсэх асуудалд анхаарал хандуулах шаардлагатай. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах чиг үүрэг хүлээсэн алба хаагч нь хуулийн болоод техникийн онолын суурь мэдлэг эзэмшсэн байхыг замын цагдаагийн албан хаагчдаас шаарддаг.

Гэтэл тус албанд ажиллаж байгаа албан хаагчдын дунд инженер техникийн мэргэжил эзэмшсэн боловсон хүчний эзлэх хувь жилээс жилд буурч байна. Энэ байдал нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах техник, технологийн шийдэл, шинэ санал, санаачилга ажил хариуцсан албан тушаалтнуудаас урган гарахгүй байх улмаар өдөр хоногийг аргацаасан шийдэл бүхий ажлын арга барилаас ажилтнууд халширч хүний нөөцийн хомсдолд ордог. Бас нэг анхаарах асуудал нь албан хаагчдыг мэргэшүүлэх ажлын байрны сургалтын хөтөлбөрүүдийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, технологи,

удирдлага, хяналтын аргачлалаа сайжруулах шаардлагатай байна.

Зөрчилд тавих хяналтын арга хэлбэр хэтэрхий хоцрогдсон байна. Судлаачдын хэлж байгаагаар Хойд Солонгос болон манай улс л хүний биечилсэн хяналтаар зөрчлийг илрүүлж, хариуцлага тооцох хэлбэрээс салаагүй байна. Энэ нь техник технологийн дэвшилд суурилсан инновацийн шийдэл бүхий ухаалаг камерын хяналтын төвтэй хараахан болоогүй байгааг сануулж байна.

Өөрөөр хэлбэл замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулахын тулд мэргэшсэн хүний нөөц, шинэ технологиудыг нэвтрүүлэх, олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх, хуулийн хэрэгжилтийг чангатгах, иргэдийн оролцоог дэмжих нь чухал гэсэн үг юм.

Иргэдийн дунд зам тээврийн ослын улмаас амь насаа алдах, эрүүл мэнд, эд хөрөнгөнд нь хохирол учрах эрсдэл маш их байгаа гэсэн болгоомжлол, сэтгэл түгшсэн байдал нь хууль сахиулах байгууллагаас хүлээсэн үүргээ иргэдийн хүсэлт шаардлагад нийцэх хэмжээнд хүртэл гүйцэтгэж чадахгүй байгааг харуулж байна.

**Дөрөв. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах арга зам**

Гадаадын зарим судлаачдын тодорхойлсноор “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” нь “Хүн -Тээврийн хэрэгсэл -Зам -Орчин” гэсэн өөр хоорондоо харилцан уялдаа холбоо, шүтэлцээ бүхий бүрэлдэхүүн хэсэг

буюу элементүүдийн нэгдэл юм” гэж<sup>158</sup> тодорхойлжээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны удирдлагыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэхийн тулд эхлээд хөдөлгөөний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг буюу элементүүдийн хэвийн найдварт ажиллагааг хангуулах зорилготой явуулж буй үйл ажиллагааны нэгдлийг тодорхойлох ёстой. Үүний дараа аюулгүй байдлын субъектээс зам тээврийн осол, зөрчил гарахад нөлөөлж буй нөхцөл байдалд идэвхтэй нөлөө үзүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, холбогдох хууль, тогтоомжид заасан эрх, үүргийнхээ хүрээнд удирдлагын шийдвэр гаргах замаар аюулгүй байдлыг хангах удирдлага хэрэгждэг.

Замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж буй үндсэн хүчин зүйлүүд нь замын хөдөлгөөнд оролцож буй иргэдийн аюулгүй байдлыг хангах төрийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох боломжийг олгодог<sup>159</sup>. Тухайлбал, Замын зураг төсөл боловсруулах, засвар, арчлалтын ажлын чанарыг сайжруулах, тээврийн хэрэгслийн завсар үйлчилгээг найдвартай хийх, жолооч бэлтгэх сургалтыг боловсронгуй болгох, иргэдийн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хөдөлгөөн зохион байгуулалтыг зөв төлөвлөх, ослын үеийн яаралтай анхны болон эмнэлгийн тусламжийг цаг алдалгүй үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа эрчимжүүлэх боломжтой.

Өөрөөр хэлбэл замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах нь олон талын хүчин чармайлт, хамтын ажиллагаа, технологийн дэвшил, эрх зүйн орчин гэх мэт хүчин зүйлсийг хамааруулсан томоохон асуудал юм. Түүнчлэн, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь зөвхөн цагдаагийн байгууллагын хариуцсан нэгжийн үүрэг бус, төрийн бүх шатны байгууллагууд, иргэд, олон нийтийн дэмжлэг, идэвхтэй оролцоог шаарддаг. Тиймээс дараах арга замуудыг санал болгож болно:

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах нь зөвхөн оновчтой удирдлагын асуудал төдийгүй нийгэм, иргэдийн хамтын оролцоо, хариуцлагын илэрхийлэл болох ёстой гэдгийг хэлэх ёстой.

### Дүгнэлт

1. Тээврийн цагдаагийн албаны бүтэц зохион байгуулалтаас харахад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавих, мөн замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг хангах зорилгоор замын хөдөлгөөнийг зохицуулах гэсэн хоёр чиг үүргийг хуулиар хүлээсэн байна.

2. Тус албаны Замын цагдаагийн газар нь нутаг дэвсгэр хариуцсан нэгжүүд, замын тээврийн бодлого төлөвлөлтийн нэгж, тусгай хамгаалалтын нэгж, зам, тээврийн

<sup>158</sup> Пугачев, И.Н. “Организация и безопасность движения”. -Хабаровск., 2004. 9 дэх тал.

<sup>159</sup> Чирков, Е.Н. Полушкин, М.Ю. Статья и “Факторы, влияющие на безопасность

дорожного движения”. Безопасность на транспорте. -Белгородский., 2014. 22 дахь тал.

хяналтын нэгж, орон нутгийн замын хяналтын нэгж, нийслэлийн хөдөлгөөн зохицуулах гэрээт нэгж гэсэн үндсэн чиг үүргийн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

3. Эдгээр нэгжүүдийн гүйцэтгэдэг гол үүрэг нь замын хөдөлгөөнд оролцож яваа жолооч нарын үйлдэлд хяналт тавих, нэгжүүдийн алба хаагчдад заавар зөвлөмж өгөх, хамгаалалт зохицуулалт хийх, түгжрэл саатлыг бууруулах биет зохицуулалт хийх, нутаг дэвсгэр хариуцсан нэгжүүдийн мэдээ тайланг авч нэгтгэх гэсэн үйл ажиллагааг явуулж байна. Үүнээс үзэхэд замын хөдөлгөөнд нөлөөлөгч элементүүдэд бүрэн хяналт тавих удирдлагын бүтэц хараахан бий болоогүйг байна.

#### Санал

1. Цаашид системийн онолын хандлагаар замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөгч элементүүдэд хяналт тавих цагдаагийн байгууллагын удирдлагын тогтолцоо, нэгжийн бүтцийн чиг үүргийг шинэчлэн тогтоох.

2. Цагдаагийн байгууллагаас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион явуулж буй бодлого, үйл ажиллагааны ач холбогдол, үр нөлөөг тодорхойлох, үнэлэлт, дүгнэлт өгөх.

3. Олон улсад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого стратегийн зорилтуудыг судлан цагдаагийн байгууллагаас зохион явуулах ажил арга хэмжээг төлөвлөх.

4. Мэргэжлийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулах, хүний нөөцийн хомсдолоос сэргийлэх зорилгоор инженер техникийн мэдлэгтэй алба хаагчдын тоог нэмэгдүүлэх гэсэн саналыг энэхүү

илтгэлтэй холбоотойгоор дэвшүүлж байна.

#### Эх сурвалжийн жагсаалт

- Хууль тогтоомж:

Цагдаагийн албаны тухай хууль (2017)

Хөдөлмөрийн тухай хууль (2021)

- УИХ, ЗГ-ын тогтоол, бодлогын баримт бичиг:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол. “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичиг.

- Ном, сурах бичиг, гарын авлага:

Улаанхүү, Ч. Аюулгүй байдал. -Уб.,2009.

Пугачев, И.Н. “Организация и безопасность движения”. -Хабаровск., 2004.

Карпов,Н.И, Павлов, Д.Б. “Основы теории обеспечения безопасности личности, овщества и государства” учебное особие. - Москва.,2000.

- Нэг сэдэвт бүртгэл:

Зам, тээврийн хөгжлийн яам. Зам, тээврийн салбарын статистикийн эмхэтгэл 2023 он. - Уб., 2024.

World health statistics 2024: Monitoring health for the SDGs, sustainable development goals. -Geneva., 2024.

- Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл:

Булган, Д. Олон нийтийн аюулгүй байдлын нэр томъёоны зарим асуудал. Эрдэм шинжилгээний илтгэл. “Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. -Уб., 2016.

Чирков, Е.Н. Полушкин, М.Ю. Статья и “Факторы, влияющие на безопасность дорожного движения”.

Безопасность на транспорте. - Белгородский., 2014.

Mireia Faus. Francisco Alonso. Article “Are Traffic Announcements Really Effective? A Systematic Review of Evaluations of Crash-Prevention Communication Campaigns”-Italia.,2021.

Ulleberg, P. Vaa, T. “Meta-analysis of the effect of road safety

campaigns on accidents.”- Phillips RO.,2011.

- Цахим эх сурвалж:

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан <https://www2.1212.mn/>.

Татаж үзсэн: 25.11.2024.